



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/610

Хэрлэн сум

Газар эзэмших тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 16.1.16 дахь заалт, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 3 дугаар 19-ны өдрийн 138 тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн зургаадугаар хуралдааны 09 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу өргөдөл гаргасан “Эрдэнэс ҮТП” ХХК-д Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт “Жонш боловсруулах цогцолбор” байгуулах зориулалтаар 762.8 га газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон, гэрээ байгуулахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Б.Сүнгээ)-д зөвшөөрсүгэй.

3.Газар эзэмших гэрээг жил бүр дүгнүүлэн, газрын төлбөрийг хугацаанд нь төлж, газар эзэмших гэрээний дагуу эзэмшихийг газар эзэмшигч “Эрдэнэс ҮТП” ХХК-д даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (А.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

